

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН,ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	8
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	11
3.5.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.2 Авлага	11
3.5.4 Урьдчилгаа	12
3.5.5 Бараа материал	12
3.5.7 Үндсэн хөрөнгө	13
3.5.8 Өр төлбөр	14
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	15
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	15
3.7 Шилэн дансны мэдээлэл.....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	17
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	17
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	18
4. Менежментийн захидал	19
4.1 Худалдан авалттай холбоотой асуудал	19
4.2 Цайны газартай холбоотой асуудал	19
4.3 Ахмадын сантай холбоотой асуудал	20
4.4 Төсвийн төлөвлөлтэй холбоотой асуудал	20
4.5 Зардалтай холбоотой асуудал.....	21
4.6 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал.....	21
4.7 Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал.....	21
4.8 Бараа материалтай холбоотой асуудал.....	22
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Ж.БОЛД ТАНАА

2021.03.25 № 01/385
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 36 зорилтын хүрээнд 88 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	57,170,127.1	62,708,968.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,049,727.5	8,767,642.4
33	АВЛАГА	752,378.6	404,953.8
34	УРЬДЧИЛГАА	3,471,178.2	3,720,436.4
35	БАРАА МАТЕРИАЛ	43,896,842.8	46,623,731.5
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	-	3,192,204.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	213,611,552.2	226,279,310.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	213,611,552.2	226,279,310.4
39200	Биет хөрөнгө	197,100,772.4	208,849,664.2
39300	Биет бус хөрөнгө	16,510,779.8	17,429,646.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	270,781,679.4	288,988,278.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,900,137.9	11,169,157.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,900,137.9	11,169,157.5
41300	Өглөг	13,078,660.5	2,301,240.3
41400	Урьдчилж орсон орлого	7,821,477.4	8,867,917.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	249,881,541.4	277,819,120.9
51	Засгийн газрын хувь оролцоо	249,881,541.4	277,819,120.9
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	82,646,375.8	83,315,093.6
51200	Хуримтлагдсан үр дүн	109,968,647.6	137,615,398.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,266,518.1	56,888,628.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	270,781,679.4	288,988,278.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	261,223,212.4	279,857,725.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,905,049.9	24,965,992.9
120	Нийтлэг татварын бус орлого	33,905,049.9	24,660,163.0
122	Тусламжийн орлого	0.0	305,829.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	227,318,162.4	254,891,732.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	214,950,057.0	251,550,754.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	214,756,440.9	251,550,754.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	191,664,323.0	228,251,286.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	131,887,591.2	155,299,326.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,085,995.6	3,864,523.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,524,076.2	5,221,378.7
2104	Хангамж, бараа материалын зардал	10,074,894.4	10,473,260.8
2105	Норматив зардал	5,930,775.3	11,753,421.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,763,244.8	4,269,905.7
2107	Томилолт, зочны зардал	985,520.9	612,677.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,144,868.5	12,433,784.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,267,356.1	24,323,008.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,092,117.8	23,299,467.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	193,616.1	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	46,273,155.3	28,306,970.7
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	46,327.3	5.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,820,376.4	1,065,115.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	44,499,106.3	27,241,860.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	249,389,439.1	270,299,019.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,989,426.5	15,115,076.5
120	Нийтлэг татварын бус орлого	21,989,426.5	15,115,076.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	227,400,012.5	255,183,942.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	213,486,929.4	252,071,931.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	213,486,929.4	252,071,931.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	181,947,127.5	217,415,695.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	131,133,134.5	154,271,457.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,046,387.6	3,989,400.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,531,709.0	5,241,864.4
2104	Хангамж, бараа материалын зардал	7,990,165.4	10,137,888.2
2105	Норматив зардал	7,181,491.4	12,958,600.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,440,566.6	8,433,356.8
2107	Томилолт, зочны зардал	998,830.4	668,995.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,148,104.1	17,481,380.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,476,738.5	4,232,751.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,539,801.9	34,656,235.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	35,902,509.6	18,227,087.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	28,042,148.0	18,500,668.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,042,148.0	18,500,668.9
2200	Дотоод эх үүсвэрээр	28,042,148.0	18,500,668.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(28,042,148.0)	(18,500,668.9)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(1,148.6)	(8,504.1)
14	Бусад эх үүсвэр	55,674.6	97,358.4
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	56,823.3	105,862.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	7,859,213.0	(282,085.1)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,190,514.5	9,049,727.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,049,727.5	8,767,642.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,293,472.2	-	205,293,472.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,939,568.7	-	1,939,568.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	207,233,040.8	-	207,233,040.8
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(1,849,452.3)	-	(1,849,452.3)
Зарласан ногдол ашиг	(1,153.3)	-	(1,153.3)
Тайлант үеийн үр дүн	44,499,106.3	-	44,499,106.3
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,881,541.4	-	249,881,541.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	413,400.5	-	413,400.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	250,294,942.0	-	250,294,942.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(377,889.7)	-	(377,889.7)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	668,717.8	-	668,717.8
Зарласан ногдол ашиг	(8,510.0)	-	(8,510.0)
Тайлант үеийн үр дүн	27,241,860.8	-	27,241,860.8
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	277,819,120.9	-	277,819,120.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	243,044,983,400.00	242,289,334,405.43	755,648,994.57	99.7
УРСГАЛ ЗАРДАЛ	235,034,483,400.00	234,774,226,052.43	260,257,347.57	99.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	211,257,652,500.00	210,999,806,428.43	257,846,071.57	99.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	149,515,243,000.00	149,434,284,935.77	80,958,064.23	99.9
Үндсэн цалин	87,056,315,700.00	87,044,456,253.44	11,859,446.56	99.9
Нэмэгдэл	58,929,009,600.00	58,862,721,596.69	66,288,003.31	99.9
Унаа хоолны хөнгөлөлт	93,280,000.00	93,280,000.00	0.00	100.0
Гэрээт ажлын хөлс	3,436,637,700.00	3,433,827,085.64	2,810,614.36	99.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,720,266,200.00	3,585,402,299.61	134,863,900.39	96.4
Тэтгэврийн даатгал	70,764,800.00	31,485,685.00	39,279,115.00	44.5
Тэтгэмжийн даатгал	7,818,300.00	10,853,049.00	-3,034,749.00	138.8
ҮОМШӨ-ний даатгал	6,255,500.00	7,319,250.00	-1,063,750.00	117.0
Ажилгүйдлийн даатгал	1,562,600.00	1,968,884.00	-406,284.00	126.0
Эрүүл мэндийн даатгал	3,633,865,000.00	3,533,775,431.61	100,089,568.39	97.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,187,854,500.00	5,183,178,262.85	4,676,237.15	99.9
Гэрэл, цахилгаан	1,900,389,000.00	1,897,872,157.33	2,516,842.67	99.9
Түлш, халаалт	2,793,342,600.00	2,792,705,708.37	636,891.63	99.9
Цэвэр, бохир ус	390,676,700.00	389,154,197.15	1,522,502.85	99.6
Байрны түрээс	103,446,200.00	103,446,200.00	0.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	8,953,033,300.00	8,951,728,459.01	1,304,840.99	99.9
Бичиг хэрэг	1,134,636,200.00	1,134,617,786.00	18,414.00	99.9
Тээвэр, шатахуун	6,405,495,900.00	6,405,430,913.60	64,986.40	99.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	831,281,900.00	831,083,256.71	198,643.29	99.9
Ном, хэвлэл	31,821,600.00	31,622,638.00	198,962.00	99.4
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	36,208,000.00	35,812,895.00	395,105.00	98.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	513,589,700.00	513,160,969.70	428,730.30	99.9
Норматив зардал	12,075,364,800.00	12,074,686,161.18	678,638.82	99.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,403,100.00	40,296,058.00	107,042.00	99.7
Хоол, хүнс	3,562,789,700.00	3,562,249,777.22	539,922.78	99.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,472,172,000.00	8,472,140,325.96	31,674.04	99.9
Эд хогшил, урсгал засварын зардал	7,707,418,500.00	7,706,401,428.00	1,017,072.00	99.9
Багаж, техник, хэрэгсэл	2,476,508,700.00	2,476,371,278.00	137,422.00	99.9
Тавилга	30,000,000.00	29,849,300.00	150,700.00	99.5
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,578,972,500.00	1,578,920,392.00	52,108.00	99.9
Урсгал засвар	3,621,937,300.00	3,621,260,458.00	676,842.00	99.9
Томилолт, зочны зардал	587,058,300.00	585,171,922.00	1,886,378.00	99.7
Гадаад албан томилолт	2,429,200.00	2,429,096.00	104.00	99.9
Дотоод албан томилолт	507,629,100.00	505,757,298.00	1,871,802.00	99.6
Зочин төлөөлөгч хүлээн авах	77,000,000.00	76,985,528.00	14,472.00	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,448,810,900.00	22,421,457,764.01	27,353,135.99	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,392,358,000.00	18,365,420,064.84	26,937,935.16	99.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,391,400.00	8,391,400.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	476,979,300.00	476,978,926.87	373.13	99.9
Тээврийн хэрэгслийн татвар	104,200,600.00	104,184,840.30	15,759.70	99.9
Тээврийн хэрэгслийн оношилгоо	26,182,800.00	25,823,730.00	359,070.00	98.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	262,491,600.00	262,491,530.00	70.00	99.9
Газрын төлбөр	62,631,900.00	62,591,992.00	39,908.00	99.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,115,575,300.00	3,115,575,280.00	20.00	99.9

Бараа үйлчилгээний бусад зардал	1,062,603,000.00	1,057,495,196.00	5,107,804.00	99.5
Бараа үйлчилгээний бусад зардал	811,008,600.00	807,026,407.00	3,982,193.00	99.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	251,594,400.00	250,468,789.00	1,125,611.00	99.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,776,830,900.00	23,774,419,624.00	2,411,276.00	99.9
Засгийн газрын урсгал шилжүүлэг	59,022,100.00	58,636,424.00	385,676.00	99.3
Засгийн газрын гадаад шилжүүлэг	59,022,100.00	58,636,424.00	385,676.00	99.3
Бусад урсгал шилжүүлэг	23,717,808,800.00	23,715,783,200.00	2,025,600.00	99.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	44,700,000.00	44,198,750.00	501,250.00	98.9
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	805,585,600.00	805,585,545.00	55.00	99.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,735,281,000.00	19,735,281,000.00	0.00	100.0
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2,503,871,500.00	2,503,871,500.00	0.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	628,370,700.00	626,846,405.00	1,524,295.00	99.8
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,010,500,000.00	7,515,108,353.00	495,391,647.00	93.8
Барилга байгууламж	6,332,400,000.00	5,899,533,390.00	432,866,610.00	93.2
Их засвар	400,000,000.00	397,665,118.00	2,334,882.00	99.4
Тоног төхөөрөмж	1,278,100,000.00	1,217,909,845.00	60,190,155.00	95.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	243,044,983,400.00	242,301,499,718.82	743,483,681.18	99.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	231,738,688,700.00	230,489,411,948.81	1,249,276,751.19	99.5
Улсын төсвөөс санхүүжих	231,738,688,700.00	230,489,411,948.81	1,249,276,751.19	99.5
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	252,495,000.00	201,630,000.00	50,865,000.00	79.9
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	252,495,000.00	201,630,000.00	50,865,000.00	79.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	11,053,799,700.00	11,610,457,770.01	-556,658,070.01	105.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,053,799,700.00	11,610,457,770.01	-556,658,070.01	105.0
Тохируулгын орлого, зарлагын зөрүү		-12,165,313.39	12,165,313.39	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		350,000.00		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		350,000.00		
БАЙГУУЛЛАГЫН ТОО	60	60		100.0
Төсвийн байгууллага	60	60		100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	10377	10298	79	99.2
Удирдах ажилтан	178	176	2	98.9
Гүйцэтгэх ажилтан	9078	9016	62	99.3
Үйлчлэх ажилтан	495	478	17	96.6
Гэрээт ажилтан	626	628	-2	100.3
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	10377	10298	79	99.2
Төрийн тусгай албан хаагч (ТТ)	9885	9820	65	99.3
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	4	2	2	50.0
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	4	4	0	100.0
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	4	4	0	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	480	468	12	97.5

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

		/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,030,226,634.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,018,695,274.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,249,151,846.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,599,286,041.25
210101	Үндсэн цалин	1,418,921,589.25
210102	Нэмэгдэл	634,330,877.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	226,069,145.00
210104	Урамшуулал	1,878,616,264.00
210105	Гэрээт ажлын хөлс	441,348,166.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	336,114,591.14
210201	Тэтгэврийн даатгал	75,777,597.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,435,334.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,862,681.00
210204	Ажилгүйдлийн даатгал	551,257.00
210205	Эрүүл мэндийн даатгал	255,487,721.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,259,124.00
210301	Гэрэл, цахилгаан	6,559,864.00
210302	Түлш, халаалт	35,490,534.00
210303	Цэвэр, бохир ус	7,208,726.00
2104	Хангамж, бараа материалын зардал	861,565,230.00
210401	Бичиг хэрэг	81,511,000.00
210402	Тээвэр, шатахуун	640,960,815.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	86,961,679.00
210404	Ном, хэвлэл	4,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,931,736.00
2105	Норматив зардал	883,914,779.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	219,800.00
210502	Хоол, хүнс	795,059,379.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	88,635,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,069,447,515.90
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,409,365,213.00
210602	Тавилга	139,574,213.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	298,236,300.00
210604	Урсгал засвар	222,271,789.90
2107	Томилолт, зочны зардал	83,823,369.00
210702	Дотоод албан томилолт	83,823,369.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,549,142,667.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,549,142,667.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,816,598,529.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,717,664,279.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	98,934,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,769,543,428.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,641,756,940.73
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	62,515,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,579,241,940.73
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	127,786,487.32
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	127,786,487.32
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,011,531,360.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,011,531,360.00
220001	Барилга байгууламж	50,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	484,760,000.00
223001	Бусад хөрөнгө	476,771,360.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,030,226,634.34
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,030,226,634.34

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	561,530,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	453,809,796.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,553,152,675.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,461,734,163.34
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч, цагдаагийн хурандаа Ж.Болд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийн төлөвлөлт, худалдан авах ажиллагааг сайжруулах, цайны газрыг аж ахуйн тооцоотой болгох, төсвийн үр ашиггүй зардалд тавих хяналтыг дээшлүүлэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 10-наас 2021 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж гүйцэтгэв.

Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 02/84 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Цагдаагийн ерөнхий газар нь “Ажил үйлчилгээ нь нийгмийн хөгжлийн эрэлт хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн амар тайван амьдралын баталгааг хангасан тэргүүлэх байгууллага болох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх,
- Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх,
- Үндсэн чиг үүргийн хүрээнд урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг дээшлүүлэх,
- Цагдаагийн байгууллага, албан хаагчийн эрх зүйн орчныг шинэчилж, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх,
- Албан хаагчдын ажлын хариуцлага, харилцааны соёл, ёс зүйн шаардлагыг хангаж ажиллах зорилт дэвшүүлэн, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахаар заасан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Цагдаагийн ерөнхий газар нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн А/87 дугаар тушаалаар салбарын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хавсралтаар баталсныг Цагдаагийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөн ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт шалгалт, аудитын хэлтэс 2020 онд харьяа 53 байгууллага, 3 хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 313 зөвлөмж өгсөн байна. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж 90.4 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Цагдаагийн ерөнхий газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 252,623.5 сая төгрөгийн 1 хувь буюу 2,526.2 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 9,049.7 сая, эцсийн үлдэгдэл 8,767.6 сая төгрөг болж, 282.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. **Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	1.2	1.0	-0.2	
Банканд байгаа бэлэн мөнгө	9,048.5	8,766.6	-281.9	100.0
Дүн	9,049.7	8,767.6	-282.1	100.0

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 8,671.4 сая төгрөг барьцаа хөрөнгийн дансанд, 68.9 сая төгрөг техник хяналтын дансанд, 16.0 сая төгрөг ахмадын сангийн дансанд, нийт 8,756.4 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, арилжааны банкны дансанд 10.2 сая төгрөг /Дотоодын цэргийн 05 дугаар анги 4.6 сая, Цагаан шонхор ТӨҮГ 5.6 сая, Монгол тамга ТӨҮГ 0.05 сая/, касст бэлэн мөнгө 1.0 сая төгрөг /Санхүү, аж ахуйн алба 0.4 сая, Цагаан шонхор ТӨҮГ 0.6 сая/ байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 752.4 сая, эцсийн үлдэгдэл 405.0 сая төгрөг болж, 347.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 **Авлагын үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	27.5	3.7	-23.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	41.5	121.3	79.8
Татаас, санхүүжилтийн авлага	1.0	49.5	48.5
Дансны авлага	287.6	121.4	-166.2
Татвар, НДШ-ийн авлага	1.1	1.4	-0.3
Бусад авлага	393.7	107.7	-286.0
<i>Байгууллагаас авах авлага</i>	<i>295.1</i>	<i>15.4</i>	<i>-279.7</i>
<i>Хувь хүмүүсээс авах авлага</i>	<i>98.6</i>	<i>92.3</i>	<i>-6.3</i>
Дүн	752.4	405.0	-347.4

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдлийн 91.1 хувь буюу 369.3 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Гэрээт албан хаагчдын 12 дугаар сарын санхүүжилтэд олгох 121.3 сая төгрөгийн авлага;
- “Монгол тамга” ТӨҮГ 80.6 сая, “Цагаан шонхор” ТӨҮГ 40.8 сая, нийт 121.4 сая төгрөгийн дансны авлага;
- Хэнтий аймаг дахь цагдаагийн газрын 9 албан хаагчдын орон сууцны хувьчлалтай холбоотой 79.1 сая төгрөгийн авлага;
- Санхүү, аж ахуйн албаны Сангийн яамнаас авах санхүүжилтийн авлага 47.5 сая төгрөгийн авлага.

Увс аймаг дахь Цагдаагийн газрын орон нутгийн барьцаа данс 286.6 сая, “Цагаан шонхор” ТӨҮГ 60.9 сая, нийт 347.5 сая төгрөгөөр авлага буурсан байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 3,471.2 сая, эцсийн үлдэгдэл 3,720.4 сая төгрөг болж, 249.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 **Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	2,020.6	1,617.0	-403.6
Урьдчилгаа тооцоо	1,450.6	2,103.4	652.8
<i>Бараа материал бэлтгэх урьдчилгаа</i>	<i>1,087.6</i>	<i>1,185.2</i>	<i>97.6</i>
<i>Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа</i>	<i>362.4</i>	<i>918.2</i>	<i>555.8</i>
<i>Цалингийн урьдчилгаа</i>	<i>0.5</i>		<i>-0.5</i>
<i>Томилолтын урьдчилгаа</i>	<i>0.1</i>		<i>-0.1</i>
Дүн	3,471.2	3,720.4	249.2

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

- Ажил үйлчилгээний урьдчилгаа 934.4 сая, 18 сарын урьдчилгаа 548.1 сая, хоолны мөнгө 88.3 сая, судалгааны ажлын урьдчилгаа 37.4 сая, гэрэл цахилгааны урьдчилгаа төлбөр 6.8 сая, сэтгүүлийн урьдчилгаа 2.0 сая, нийт 1,617.0 сая төгрөгийн урьдчилж төлсөн зардал,
- Санхүү, аж ахуйн алба хувцас, мах, зөөврийн сууц 1,028.4 сая, гэрээт харуул хамгаалалт 151.9 сая, Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар нүүрс 4.9 сая нийт 1,185.2 сая төгрөгийн бараа материал бэлтгэх урьдчилгаа,
- Санхүү, аж ахуйн алба автомашин, түрээсийн автобус 863.5 сая, Ховд аймаг дахь Цагдаагийн газар Баруун бүсийн сургалтын төвийн барилга 54.7 сая, нийт 918.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа төлбөрүүд байна.

“Ди би эм лизинг” ХХК-д түрээсийн гэрээгээр төлсөн 169.1 сая, шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдэд эргүүл, хяналт тавих зориулалттай тусгай тоноглол бүхий 4 автомашин худалдан авах хугацаа хойшилсноос 390.2 сая, үйлдвэрт олгох алба хаагчдын хувцасны

материал, дагалдах хэрэгсэл хойшилсноос шалтгаалж 93.9 сая төгрөг, нийт 653.2 сая төгрөгөөр урьдчилгаа тооцоо өссөн байна.

3.5.5 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 43,896.8 сая, эцсийн үлдэгдэл 46,623.7 сая төгрөг болж, 2,726.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №.4 **Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	14,017.0	14,208.6	191.6
Тусгай зориулалттай материал	13,928.9	14,021.3	92.4
Эм боох материал	88.1	187.3	99.2
Дуусаагүй үйлдвэрлэл	2,735.5	0.0	-2,735.5
Бэлэн бүтээгдэхүүн	5,953.0	6,301.9	348.9
Хангамжийн материал	20,382.3	25,277.4	4,895.1
Бичиг хэргийн материал	1,525.3	3,421.7	1,896.4
Аж ахуйн материал	1,497.7	1,898.3	400.6
Сэлбэг хэрэгсэл	154.9	226.6	71.7
Түлш, шатах тослох материал	265.9	1,682.2	1,416.3
Барилгын засварын материал	196.5	248.3	51.8
Хүнсний материал	65.7	187.5	121.8
Бусад хангамжийн материал	16,676.4	17,612.8	936.4
Мал амьтад	809.1	835.8	26.7
Дүн	43,896.8	46,623.7	2,726.9

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд худалдан авсан 46,068.5 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 18,666.6 сая, үнэ төлбөргүй 653.0 сая, хандиваар 297.3 сая, залруулгаар 231.5 сая нийт 65,916.9 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн, зарцуулсан 26,631.5 сая, балансаас баланст шилжүүлсэн 34,095.5 сая, залруулгаар 1,553.5 сая, акталсан 909.4 сая, нийт 63,189.9 сая төгрөгийн бараа материал хасагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн конторын барилга 2,992.2 сая, Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газрын конторын барилга 200.0 сая нийт 3,192.2 сая төгрөгийн хөрөнгө бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байна.

Монголын үнэт цаас ХХК-аас 2020 оны 4 дүгээр сард нийлүүлэгдэх байсан жолооны үнэмлэхийн бэлдэц Ковид-19 цар тахалтай холбоотой хил дээр хүлээгдэж 2020 оны 9 дүгээр сард нийлүүлэгдсэн. Мөн 2020 оны 11 дүгээр сард бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэнтэй холбогдуулан голомтод болон эрсдэлтэй бүсэд эргүүл, хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслийн худалдан авалтыг хийсэнтэй холбоотой нийт 2,726.9 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 213,611.6 сая, эцсийн үлдэгдэл 226,279.3 сая төгрөг болж, 12,667.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 5 **Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	197,100.8	208,849.7	11,718.9
Барилга, байгууламж, орон сууц	143,497.0	152,491.3	8,994.3
Хуримтлагдсан элэгдэл	-8,019.5	-12,015.6	-3,996.1
Авто тээврийн хэрэгсэл	27,298.7	32,415.3	5,116.6
Хуримтлагдсан элэгдэл	-11,234.7	-12,597.5	-1,359.7
Машин тоног төхөөрөмж/компьютер/	46,504.8	50,742.3	4,237.4

Хуримтлагдсан элэгдэл	-13,407.4	-19,572.0	-6,164.6
Тавилга, аж ахуйн эд хогшил	7,408.2	8,637.9	1,229.7
Хуримтлагдсан элэгдэл	-2,679.1	-3,424.2	-745.0
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	4,654.0	4,665.4	11.4
Хуримтлагдсан элэгдэл	-128.2	-128.2	0
Бусад биет бус хөрөнгө	4,155.6	8,959.0	4,803.4
Хуримтлагдсан элэгдэл	-951.6	-1,327.0	-375.4
Дуусаагүй барилга, байгууламж	3.0	0	-3.0
Биет бус хөрөнгө	16,510.8	17,429.6	918.8
Программ хангамж	1,190.5	1,659.5	469.0
Хуримтлагдсан элэгдэл	-588.3	-725.7	-137.4
Бусад биет бус хөрөнгө	16,060.4	16,706.1	645.6
Хуримтлагдсан элэгдэл	-151.9	210.2	-58.4
Дүн	213,611.6	226,279.3	12,667.7

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 8,900.9 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 21,975.5 сая, хөрөнгийн дахин үнэлгээгээр 6,184.6 сая, газрын эзэмших эрх бүртгэснээс 1,026.5 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 8.5 сая, нийт 38,096.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас баланст шилжүүлсэн 2,216.6 сая, акталсан 4,493.0 сая, дахин үнэлгээгээр 5,881.9 сая хорогдож, нийт 12,591.5 сая төгрөгөөр хасагдсан байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 20,900.1 сая, эцсийн үлдэгдэл 11,169.2 сая төгрөг болж, 9,730.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 6 **Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	20,900.1	11,169.2	-9,730.9	100.0
Өглөг	13,078.7	2,301.2	-10,777.5	20.6
Ажилчидтай холбогдсон өглөг	25.3	4.3	21.0	
Бусад өглөг	13,053.4	2,297.0	-10,756.4	20.6
Байгууллагад төлөх өглөг	1,656.0	2,205.1	549.1	19.7
Хувь хүмүүст төлөх өглөг	11,327.7	0	-11,327.7	
Татварын өглөг	68.5	63.6	-4.9	0.6
Дансны өглөг	1.2	28.3	27.1	0.3
Урьдчилж орсон орлого	7,821.5	8,867.9	1,046.4	79.4
Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	7,364.4	8,671.5	1,307.1	77.6
Бусад урьдчилж орсон орлого	457.1	196.4	-260.7	1.8
Нийт дүн	20,900.1	11,169.2	-9,730.9	100.0

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийслэлийн цагдаагийн удирдах газар “Моннис Моторс” ХХК-д 2,029.8 сая, Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар орон сууцны төлбөр 72.8 сая, Санхүү, аж ахуйн алба “Тотал технологи” ХХК-д 52.8 сая, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 47.4 сая, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газарт 2.3 сая, нийт 2,205.1 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг, “Монгол Тамга” ТӨҮГ 52.5 сая, “Цагаан шонхор” ТӨҮГ 11.1 сая, Дотоодын цэргийн 05 дугаар анги 4.3 сая, нийт 67.9 сая төгрөгийн татварын өглөг, “Цагаан шонхор” ТӨҮГ 22.9 сая, “Монгол тамга” ТӨҮГ 5.4 сая, нийт 28.3 сая төгрөгийн дансны байна.

Өр төлбөр буурсан шалтгаан нь 2019 онд үүссэн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн өр бүрэн барагдуулсантай холбоотой.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 249,881.5 сая, эцсийн үлдэгдэл 277,819.1 сая төгрөг болж, 27,937.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7 **Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/**

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	82,646.4	83,315.1	668.7	30.0
Хуримтлагдсан үр дүн	109,968.6	137,615.4	27,646.8	49.5
Өмнөх үеийн үр дүн	65,469.5	110,373.5	44,904.0	39.7
Тайлант үеийн үр дүн	44,499.1	27,241.9	-17,257.2	9.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	57,266.5	56,888.6	-377.9	20.5
Дүн	249,881.5	277,819.1	27,937.6	100.0

Эх сурвалж: Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 277,819.1 сая төгрөг болж 27,937.6 сая төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн 27,646.8 сая төгрөгөөр, Засгийн газрын оруулсан капитал 668.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, хөрөнгийн дахин үнэлгээ 377.9 сая төгрөгөөр хорогдсон байна. Үүнд:

Төрийн өмчийн дансны үлдэгдэл 83,315.1 сая төгрөг болж 668.7 сая төгрөгөөр өссөн нэр бүхий 11 байгууллагын газрыг үнэлж, газар эзэмших эрх 1,026.4 сая төгрөгөөр нэмэгдсэн, Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн газрын газар эзэмших эрхийн үнийг 268.2 сая төгрөгөөр бууруулж залруулсан, Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газрын газар эзэмших эрх, барилгын хамтаар 89.5 сая төгрөгийн хөрөнгийг бусдад шилжүүлж, бүртгэсэн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 56,888.6 сая төгрөг болж 377.9 сая төгрөгөөр буурсан нь Хүч спорт хорооны барилгын дахин үнэлгээгээр 10.9 сая төгрөгөөр нэмэгдэж, нэр бүхий 17 байгууллагын данс бүртгэлээс хасагдсан хөрөнгийн 388.8 сая төгрөгийн дахин үнэлгээний буцаалтаас шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 137,615.6 сая төгрөг болж 27,646.8 сая төгрөгөөр өссөн нь тайлан үеийн үр дүн 27,241.9 сая төгрөгт хүрсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 560,697.6 сая төгрөгөөр, урсгал зарлагыг 356,779.0 сая, хөрөнгө оруулалтын зардлыг 203,918.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 317,652.6 сая төгрөгөөр бууруулж, 243,045.0 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь урсгал зарлагыг 121,744.5 сая, хөрөнгө оруулалтын зардлыг 195,908.1 сая төгрөгөөр тус тус бууруулжээ.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 243,045.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 235,034.5 сая төгрөгийг урсгал зардалд, 8,010.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын эх үүсвэрийн 231,738.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 252.5 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 11,053.8 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 231,243.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 201.6 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, нийт 231,444.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь төлөвлөснөөс 546.5 сая төгрөг дутуу санхүүжүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 11,610.5 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 556.7 сая төгрөгөөр давсан нь байгууллагууд орлогоо давуулсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 242,289.3 сая төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь хөрөнгийн зардал 495.4 сая, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 81.0 сая, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл 134.9 сая. бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 27.3 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 753.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 14 төсөл, арга хэмжээнд 8,010.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 7,515.1 сая төгрөг санхүүжигдсэнээс гүйцэтгэгч байгууллагад 6,501.4 сая төгрөгийг ажлын гүйцэтгэлээр олгож, 580.8 сая төгрөгийг барьцаа дансанд, 68.9 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар Нэгдсэн үндэсний байгууллагаас 431.4 сая, Дэлхийн байгаль хамгаалах сангаас 101.1 сая, Улаан загалмайн нийгэмлэгээс 20.0 сая, иргэн Борбаатар 5.0 сая, “Эрчим Баян Өлгий” ХХК-аас 4.0 сая, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 453.8 сая, дээд шатны төсвийн захирагчаас 9,553.2 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 12,461.7 сая, нийт 23,030.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тэтгэмж, шагнал урамшуулалд 8,641.8 сая, цалингийн зардалд 4,599.3 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 2,816.6 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 2,069.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 1,549.1 сая, хөрөнгийн зардалд 1,011.5 сая, норматив зардалд 883.9 сая, хангамж, бараа материалын зардалд 861.6 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 336.1 сая, томилолт, зочны зардалд 83.8 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 49.3 сая нийт 22,902.4 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 127.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 7897 мэдээллээс 7561 мэдээллийг хугацаанд нь, 336 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 6.4 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, 61.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага, 1,654.5 сая төгрөгийн 58 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэг-жилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	6	6.4	6	6.4			100.0
Албан шаардлага	10	61.2	9	61.2	1		90.0
Зөвлөмж	58	1,654.5	57	1,650.0	2	4.5	98.3
Нийт	74	1,722.1	72	1,717.6	2	4.5	97.3

/сая төгрөг/

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 54 төсвийн байгууллага, 2 төрийн өмчит аж ахуйн нэгж, нийт 56 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 35 байгууллагад дүгнэлт гаргаж, 19 байгууллага түүврээр хамрагдсан, 1 байгууллага нууцын зэрэглэлтэй, “Монгол тамга” ТӨҮГ-ыг татан буулгах шийдвэр гарсан боловч хаалтын тайлан гараагүй зэрэг шалтгаанаар аудитад хамруулаагүй байна.

Аудитад хамрагдсан харьяа 35 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 4,044.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1,596.4 сая төгрөгийн 42 алдааг аудитын явцад залруулж, 18.0 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 675.8 сая төгрөгийн 14 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1,754.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 64 зөвлөмжийг хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн 839.9 сая төгрөгийн зөрүүг залруулав. Үүнд:

- **Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд** мөнгөн хөрөнгийг 4.6 сая төгрөгөөр, бараа материалыг 120.0 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийг 6.9 сая төгрөгөөр, өр төлбөрийг 0.9 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүнг 130.6 сая төгрөгөөр тус тус илүү нэгтгэсэн;
- **Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд** үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 209.6 сая, жижиг мөнгөн сангийн орлого 4.6 сая төгрөгөөр тус тус илүү, тусламжийн орлогыг 202.7 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 7.7 сая төгрөгөөр тус тус дутуу нэгтгэсэн;
- **Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд** нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 120.0 сая төгрөгөөр, тайлант үеийн үр дүн 19.2 сая төгрөгөөр тус тус илүү, зарласан ногдол ашиг 8.5 сая төгрөгөөр дутуу нэгтгэж, 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл 130.6 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн;

- **Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд** 4.6 сая төгрөгөөр нийтлэг татварын бус орлого илүү нэгтгэж, мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл илүү илэрхийлэгдсэн байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

ЦЕГ-ын 2020 оны урсгал зардлын төсвөөс 445.0 сая төгрөгийн 300 ширхэг суурин компьютер, 63.6 сая төгрөгийн 40 ширхэг зөөврийн компьютер, 42.0 сая төгрөгийн архивын 60 ширхэг шүүгээ, нийт 550.6 сая төгрөгийн хөрөнгийг дараах үндсэн хөрөнгийг бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

ЦЕГ-ын харьяа төсвийн шууд захирагчдын /Нийслэл, орон нутгаас бусад/ 2020 оны батлагдсан төсөвт орон тоо 3571, гүйцэтгэлээр 3783 буюу 212 орон тоогоор хэтэрсэн байна. Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолоор ЦЕГ-ын төв байрны албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг 298-р баталснаас 88 орон тоогоор илүү байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 7897 мэдээллээс 7561 мэдээллийг хугацаанд нь, 336 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.4.1, 6.4.4, 6.4.5, 6.4.9-т заасантай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Төвлөрүүлэн захирагч болон харьяа түүврээр хамрагдсан төсвийн шууд захирагчдад өгсөн 1,120.3 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах 8 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,533.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 756.4 сая төгрөгийн 22 алдааг аудитын явцад залруулж, 18.0 сая төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 125.0 сая төгрөгийн 11 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 634.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 56 зөвлөмжийг хүргүүлээ.

3.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор “Монгол тамга” ТӨҮГ-ыг татан буулгах ажлыг ХЗДХЯ, ТӨБЗГ-тай хамтран хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, дүнг Засгийн газарт танилцуулж, гүйцэтгэлийг тайлагнахыг даалгасан боловч одоо хүртэл шийдвэрлэгдээгүй нь анхаарал татахуйц асуудал байна.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 ХУДАЛДАН АВАЛТТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.1.1 Илрүүлэлт:

Харьяа байгууллагуудын дансны хуулга, цахим и-баримтыг тулган шалгахад тайланд хугацааны бараа ажил үйлчилгээний 394.1 сая төгрөгийн худалдан авалтын цахим и-баримтыг бүрдүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “бараа ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “ Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсвэл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсвэл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4.1.2 Эрсдэл:

Төсөв хяналтгүй зарцуулагдах, худалдан авалт бодитоор хийгдэхгүй байх, орлогоо нуун дарагдуулах боломжийг бусдад олгох, татварын орлого дутуу бүрдэх.

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримттай бараа, үйлчилгээг авч байх, цаг тухайд нь цахим и-баримтыг хангуулах бүртгэлд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах,

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

4.2 ЦАЙНЫ ГАЗАРТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.2.1 Илрүүлэлт:

Тус газрын 5 дугаар давхарт ажиллах цайны газарт 2020 онд Хангалт үйлчилгээний төвөөс цэрэг, цагдаагийн 5, энгийн 3, нийт 8 ажилтан ажиллуулж 87.4 сая төгрөгийн цалин олгон, Захиргаа удирдлагын газраас 119.3 сая, мөн 2 дугаар давхарт ажиллах кофе шопод 8.3 сая төгрөгийн хүнсний материал тус тус зарцуулж, цэгүүдийн хамгаалалтад ажиллаж буй албан хаагчид хүргүүлсэн хоолны үнээс 18.2 сая, цайны газраас 88.0 сая, кофе шопоос 10.0 сая, нийт 116.2 сая төгрөгийн орлоготой ажиллаж, цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол тооцолгүйгээр 98.8 сая төгрөгийн алдагдалтай байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-т “төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 6.4.3-т “иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой хөтөлбөр, арга хэмжээг тэдгээрээр гүйцэтгүүлэх чиглэл баримтлах”, 6.4.4-т “хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4.2.2 Эрсдэл:

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого олоход зориулагдсан зардал орлогоосоо давах

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Цайны газрыг аж ахуйн тооцоотой ажиллуулах, зарцуулагдаж байгаа зардлыг орлогын хэмжээнд дүйцүүлэх

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

4.3 Ахмадын сантай холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт:

Ахмадын сан үүсгэж, төсөв батлагдаагүй байхад ахмад настанд хүндэтгэл үзүүлэхэд зориулж урсгал зардлын Засгийн газрын гадаад шилжүүлгийн ангиллаас 208.9 сая төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4.3.2 Эрсдэл:

Төсвийг зориулалт бусаар зарцуулах

4.3.3 Өгсөн зөвлөмж:

Ахмадын сангийн төсөв батлуулж, зарлага гаргах

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

4.4 Төсвийн төлөвлөлтэй холбоотой асуудал

4.4.1 Илрүүлэлт:

Цагдаа, дотоодын цэргийн 36 анги байгууллагаас ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд 91.3 сая, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 34.3 сая төгрөгийг шилжүүлж зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 5.1-д “Төсвийн байгууллага энэ журмын 3.1.4-т заасан үндэслэлээр цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын бүлэг болон дангаар хянагдах зардлын бүлэглэлээс бусад зардлын бүлэг хооронд жилийн батлагдсан төсвийн тухайн зардлын бүлгийн дүнг 20 хүртэл хувиар нэмэгдүүлэх зохицуулалтын хүсэлт гаргаж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

4.4.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан болон зардлын ангилал буруу илэрхийлэгдэх,

4.4.3 Өгсөн зөвлөмж:

Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг зөв төлөвлөж, батлуулах

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

4.5 ЗАРДАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.5.1 Илрүүлэлт:

Цагдаагийн байгууллагын сүр хүчний бэлгэдэл "бэрээ" шувууны дүрстэй бэлэг дурсгалын зүйлсийг 75.5 сая, алба хаагчдад зориулж дурсгалын мөнгөн бөгжийг /770 ширхэг/ 50.0 сая төгрөгөөр тус тус гэрээгээр гүйцэтгүүлж, үр дүнгүй зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

4.5.2 Эрсдэл:

Төсөв үр ашиггүй зарцуулагдах,

4.5.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийг үр ашиггүй зарцуулахгүй байх,

4.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

4.6 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.6.1 Илрүүлэлт:

Дотоодын цэргийн 805 дугаар анги худалдан авалтын гэрээнд үнийн дүн тусгаагүйгээр 22.8 сая төгрөгийн хоол, хүнсний материал, 14.4 сая төгрөгийн аж ахуйн материал худалдан авсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-т "Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараах нөхцөлийг заавал тусгана", 40.3.1-т "гэрээний үнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

4.6.2 Эрсдэл:

Худалдан авалт бодитоор хийгдэхгүй байх, залилан үүсэх,

4.6.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авах гэрээнд хуульд заасан нөхцөлийг бүрэн тусгаж, ажиллах

4.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

4.7 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.7.1 Илрүүлэлт:

Дотоодын цэргийн 805 дугаар анги 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй бараа материалыг харьцуулалтын арга хэрэглэлгүй, гэрээ байгуулалгүй, 14.0 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн. Энэ нь Босго үнэ шинэчлэн батлах тухай Засгийн газрын 68 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

4.7.2 Эрсдэл:

Хууль тогтоомжууд зөрчигдөж, худалдан авалт бодитоор хийгдэхгүй байх, залилан үүсэх

4.7.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж, ажиллах

4.7.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

4.8 БАРАА МАТЕРИАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.8.1 Илрүүлэлт:

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын “Би хороохгүй” аяны санхүүжилтээр хийгдсэн контентыг Мөрдөн байцаах алба шууд зардалд бүртгэсэн. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.15-д "Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс, худалдах зориулалтаар хадгалагдаж байгаа (улсын нөөцийн бараа зэрэг) бэлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн процесст байгаа хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэрэг болно" гэж заасантай нийцэхгүй байна.

4.8.2 Эрсдэл:

Бараа материалд бүртгэлээр тавих хяналт алдагдах

4.8.3 Өгсөн зөвлөмж:

Бараа материалын бүртгэж, зарцуулах

4.8.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	Аудитын код:
2020 он			САГ-2021/5/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Цагдаагийн ерөнхий газар		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
Төсвийн төвлөрүүлэн захирагч					
	ЦЕГ-ын харьяа төсвийн шууд захирагчдын /Нийслэл, орон нутгаас бусад/ 2020 оны батлагдсан төсөвт орон тоо 3571, гүйцэтгэлээр 3783 буюу 212 орон тоогоор хэтэрсэн байна.	-	Албан шаардлага	Санхүү, аж ахуйн албаны дарга, Хэлтсийн дарга	П.Батбаатар, Н.Алтансүх
	ЦЕГ-ын 2020 оны урсгал зардлын төсвөөс 300 ширхэг суурин компьютер 445.0 сая, 40 ширхэг зөөврийн компьютер 63.6 сая, архивын 60 ширхэг шүүгээ 42.0 сая нийт 550.6 сая төгрөгийн хөрөнгийг дараах үндсэн хөрөнгийг бэлтгэсэн байна.	550.6	Албан шаардлага	Санхүү, аж ахуйн албаны дарга, Хэлтсийн дарга	П.Батбаатар, Н.Алтансүх
	Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 7897 мэдээллээс 7561 мэдээллийг хугацаанд нь, 336 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	-	Албан шаардлага	Санхүү, аж ахуйн албаны дарга, Хэлтсийн дарга	П.Батбаатар, Н.Алтансүх
	Тус газрын цайны газарт 2020 онд Хангалт үйлчилгээний төвөөс цэрэг, цагдаагийн 5, энгийн 3, нийт 8 ажилтан ажиллуулж 87.4 сая төгрөгийн цалин олгон, Захиргаа удирдлагын газраас 119.3 сая, кофе шопод 8.3 сая төгрөгийн хүнсний материал тус тус зарцуулж, цэгүүдийн хамгаалалтад ажиллаж буй албан хаагчид хүргүүлсэн хоолны үнээс 18.2 сая, цайны газраас 88.0 сая, кофе шопоос 10.0 сая, нийт 116.2 сая төгрөгийн орлоготой ажиллаж, цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол тооцолгүйгээр 98.8 сая төгрөгийн алдагдалтай хүлээж байна.	215.0	Зөвлөмж	Санхүү, аж ахуйн албаны дарга, Хэлтсийн дарга	П.Батбаатар, Н.Алтансүх
	Ахмадын сан үүсгэж, төсөв батлагдаагүй байхад ахмад настанд хүндэтгэл үзүүлэхэд зориулж урсгал зардлын 213209 /Засгийн газрын гадаад шилжүүлэг/ -н ангиллаас 208.9 сая төгрөг зарцуулсан байна.	208.9	Зөвлөмж	Санхүү, аж ахуйн албаны дарга, Хэлтсийн дарга	П.Батбаатар, Н.Алтансүх
4	Харьяа байгууллагуудын дансны хуулга, Е баримтыг тулган шалгахад тайланд хугацааны зарим худалдан авалтын төлбөр Е баримтгүй 394.1 сая төгрөг, бэлтгэн нийлүүлэгч байгууллага Е баримтын дүнгээс зөрүүтэй төлбөр	394.1	Зөвлөмж	Санхүү, аж ахуйн албаны дарга, Хэлтсийн дарга	П.Батбаатар, Н.Алтансүх

	шилжүүлсэн /баримтын бүрдэл ханган/ ажиллаагүй байна.				
7	Цагдаа, дотоодын цэргийн 36 анги байгууллагаас ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд 91.3 сая, цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 34.3 сая төгрөгийг шилжүүлж зарцуулсан байна.	125.6	Зөвлөмж	Санхүү, аж ахуйн албаны дарга, Хэлтсийн дарга	П.Батбаатар, Н.Алтансүх
8	Цагдаагийн байгууллагын сүр хүчний бэлгэдэл "бэрээ" шувууны дүрстэй бэлэг дурсгалын зүйлсийг 75.5 сая, алба хаагчдад зориулж дурсгалын мөнгөн бөгжийг /770 ширхэг/ 50.0 сая төгрөгөөр тус тус гэрээгээр гүйцэтгүүлж, үр дүнгүй зардал гаргасан байна.	125.5	Зөвлөмж	Санхүү, аж ахуйн албаны дарга, Хэлтсийн дарга	П.Батбаатар, Н.Алтансүх
Дотоодын цэргийн 805 дугаар анги					
9	худалдан авалтын гэрээнд үнийн дүн тусгаагүйгээр 22.8 сая төгрөгийн хоол, хүнсний материал, 14.4 сая төгрөгийн аж ахуйн материал худалдан авсан.	37.2	Зөвлөмж	Санхүү, аж ахуйн албаны дарга, Хэлтсийн дарга	П.Батбаатар, Н.Алтансүх
10	10 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй бараа материалыг харьцуулалтын арга хэрэглэлгүй, гэрээ байгуулалгүй, 14.0 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн.	14.0	Зөвлөмж	Санхүү, аж ахуйн албаны дарга, Хэлтсийн дарга	П.Батбаатар, Н.Алтансүх
Мөрдөн байцаах алба					
11	Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын "Би хороохгүй" аяны санхүүжилтээр хийгдсэн контентыг шууд зардалд бүртгэсэн.		Зөвлөмж	Санхүү, аж ахуйн албаны дарга, Хэлтсийн дарга	П.Батбаатар, Н.Алтансүх
Архангай аймаг дахь Цагдаагийн газар					
	Шинжээчийн хөлс олгохдоо Засгийн газрын 2018 оны 161 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2010 оны 112 тоот тушаалын 2 дугаар хавсралтыг мөрдөөгүй, албан томилолтын зардлыг 742.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон	0.7	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	А.Лхагвадорж Г.Жүгдэр
Баян Өлгий аймаг дахь Цагдаагийн газар					
	Шатахууныг талоноор худалдан авч орлогод аваад, зарцуулалтын тооцоог хийхдээ литрээр дахин орлого авч, зарцуулснаас орлогыг 1.388.9 мянган төгрөгөөр илүү харуулсан, 3 хүнд олгосон 757.9 мянган төгрөгийн урьдчилгааг суутгаагүй	2.1	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Б.Наранбаатар Б.Батсүх
Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар					
	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 11 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн	-	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Б.Оюутболд О.Сувд-Эрдэнэ
Булган аймаг дахь Цагдаагийн газар					
	Давхардсан тоогоор 109 албан хаагчдад сарын ажлыг дүгнэж 11.603.6 мянган төгрөгийн цалингийн нэмэгдэл олгосон, 3.084.7 мянган төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн, ангилал зөрүүтэй хөрөнгө бараа материалд бүртгэлтэй	14.7	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Л.Ганбаатар Б.Манлай

	Эд хөрөнгийн тооллогын бүртгэлийн баримт дутуу, архивын нэгж болгоогүй	-	Албан шаардлага	Дарга Ахлах нягтлан бодогч	Л.Ганбаатар Б.Манлай
Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газар					
	Амралтаа биеэр эдлээгүй 6 ажилтанд урамшуулал олгоогүй, 9 ажилтантай амралтын тооцоо хийгээгүй, 25,045.7 мянган төгрөгийн и-баримтгүй худалдан авалт хийсэн	25.0	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Н.Эрдэнэ-Очир Г.Идэрхангай
	Байгууллагын даргын тушаалаар алба хаагчдын цалин хасаж, нэмэхдээ тушаалаас зөрүүлэн 960.4 мянган төгрөг илүү, 1.857.5 мянган төгрөг дутуу олгосон	2.8	Төлбөрийн акт	Дарга Ахлах нягтлан бодогч	Н.Эрдэнэ-Очир Г.Идэрхангай
	Жолоочийн тооцооны хуудсаар 449.2 л шатахуун буюу 687.5 мянган төгрөгийг зарцуулснаар, 356.7 л шатахуун буюу 585.6 мянган төгрөгийг спидометрийн заалт давхардуулан зардалд тусгасан.	1.3	Төлбөрийн акт	Дарга Ахлах нягтлан бодогч	Н.Эрдэнэ-Очир Г.Идэрхангай
	Шатахууны тооцоо бодсон боловч хяналт хангалтгүй өмнөх аудитаар өгөгдсөн 3 төрлийн зөрчил давтагдсан	-	Албан шаардлага	Дарга Ахлах нягтлан бодогч	Н.Эрдэнэ-Очир Г.Идэрхангай
	Төсвийн хэлбэлзлээр урсгал засварын зардал 2,651.7 мянган төгрөгөөр илүү дүнгээр зарцуулах эрхийг илүү зарцуулсан	2.7	Албан шаардлага	Дарга Ахлах нягтлан бодогч	Н.Эрдэнэ-Очир Г.Идэрхангай
	Онцгой байдлын үед постод гарахад 1,069.0 мянган төгрөгийн шатахууныг зогсолтын үед зарцуулсан боловч мото цагаар тооцоогүй.	1.1	Албан шаардлага	Дарга Ахлах нягтлан бодогч	Н.Эрдэнэ-Очир Г.Идэрхангай
	Цалингийн зардлаас 5.267.8 мянган төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж олгосон	5.3	Албан шаардлага	Дарга Ахлах нягтлан бодогч	Н.Эрдэнэ-Очир Г.Идэрхангай
	Байгууллагын даргын хөрөнгө зарцуулах 4 тушаал, 5 сая төгрөгөөс дээш дүнтэй орлого, зарлагын гүйлгээ, 3 худалдан авалт, төсөвт орсон өөрчлөлт, 3 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ мэдээлээгүй	-	Албан шаардлага	Дарга Ахлах нягтлан бодогч	Н.Эрдэнэ-Очир Г.Идэрхангай
Говь-сүмбэр аймаг дахь Цагдаагийн газар					
	Даатгуулагчаас төлөх НДШ-ийг ажил олгогчоос төлсөн, ажлын цагийн тооцоонд цалин, ээлжийн амралтын хоног зөрүүтэй бүртгэсэн, байгууллагын удирдлага эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр урамшуулал авсан, худалдан авалтыг татварын цахим бүртгэлтэй тулгаж хяналт тавиагүй зөрүү үүссэн	2.1	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Ц.Баярхүү, Л.Гүнжинлхам
	Төсвийн тухай хуулийг зөрчиж төсвийн зардлын зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй, хэрэглээнээс илүүдэл 5.100.0 мянган төгрөгийн шатахууны нөөц бүрдүүлсэн	5.1	Төлбөрийн акт	Дарга Ахлах нягтлан бодогч	Ц.Баярхүү, Л.Гүнжинлхам
	Алба хаагчдад улирал бүр урамшуулал олгосон ба жилийн дүнгээр нийт 54 алба хаагчид 8.195.0 мянган төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон	8.2	Төлбөрийн акт	Дарга Ахлах нягтлан бодогч	Ц.Баярхүү, Л.Гүнжинлхам
	Шилэн дансны цахим хуудсанд автомашин худалдан авах тендер шалгаруулалттай холбоотой Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг	-	Албан шаардлага	Дарга Ахлах нягтлан бодогч	Ц.Баярхүү, Л.Гүнжинлхам

	сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг /тухай бүр/ мэдээлээгүй				
Дорнод аймаг дахь Цагдаагийн газар					
	Цагдаагийн газрын сарын хэрэглээнээс илүү хэмжээгээр 11.901.2 мянган төгрөгөөр шатахуун нөөцөлсөн	11.9	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Т.Ганзориг, Б.Даваадорж
	Нэмэлт санхүүжилтийн дансны 5.0 сая төгрөгөөс дээш орлогын гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй	113.3	Албан шаардлага	Дарга Ахлах нягтлан бодогч	Т.Ганзориг, Б.Даваадорж
Дундговь аймаг дахь Цагдаагийн газар					
	Цалингийн цэстэд хасах тохируулгаар цалин тооцож олгосон	-	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Г.Наранбаатар, Ц.Нарантогос
Орхон аймаг дахь Цагдаагийн газар					
	Эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл НХ маягт БМ-10 маягтаар хөтлөөгүй, нярвын ажлыг хавсруулан гүйцэтгүүлэхээр өгсөн ч эд хөрөнгийн тооллого хийж баримтжуулаагүй	-	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	С.Цэрэнсамбуу Г.Дамчаа
	Тус газрын даргын тушаалаар нягтлан бодогч А.Ариунтуяад нярвын ажлыг хавсруулан 149.3 мянган төгрөг олгосон	0.1	төлбөрийн акт	Дарга Ахлах нягтлан бодогч	С.Цэрэнсамбуу Г.Дамчаа
	Баривчлах байранд баривчилсан иргэдээс 10 иргэний 449.0 мянган төгрөгийн төлбөр төлөгдөөгүй	0.5	төлбөрийн акт	Дарга Ахлах нягтлан бодогч	С.Цэрэнсамбуу Г.Дамчаа
Өмнөговь аймаг дахь Цагдаагийн газар					
	Шилэн дансны цахим хуудсанд 149 мэдээлэл байршуулахаас 26 мэдээ хоцроосон, 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогын 95, зарлагын 27 мэдээлэл байршуулаагүй	-	Албан шаардлага	Дарга Ахлах нягтлан бодогч	Н.Мишигдорж Г.Батбилэг
Сүхбаатар аймаг дахь Цагдаагийн газар					
	Саатуулах байрны орлогын анхан шатны бүртгэл хөтлөлт хангалтгүй	1.9	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Д.Батчулуун Ц.Алтанзул
Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газар					
	Байгууллагаас төлөх НДШ-ийг цалинтай уялдуулж төлөвлөөгүй, хууль эрх зүйн актын үндэслэл буруу тушаалаар урамшуулал олгосон, цалингийн суутгалыг стандартын дагуу суутгаагүй, шилэн дансны цахим хуудсанд 2 мэдээлэл хугацаа хоцроосон	15.7	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	А.Энхбат Д.Мягмар
Төв аймаг дахь Цагдаагийн газар					
	2019 оны албан томилолтын 874.0 төгрөгийн 2020 онд олгосон, 23 гүйлгээ и-баримтаар баталгаажуулаагүй худалдан авалт хийсэн, шилэн дансны цахим хуудсанд 5 саяас дээших худалдан авалтын 35 гүйлгээ мэдээлээгүй	5.5	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Б.Ганзориг Н.Дашдаваа
Ховд аймаг дахь Цагдаагийн газар					
	Тайлант онд төсөвт байгууллагын чиг үүрэгт хамааралгүй үйл ажиллагааг санхүүжүүлсэн 495.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн	0.5	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Э.Даваасүрэн, Д.Рагчаадорж
Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газар					
	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 38 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан	-	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	

					Д.Дашням, Н.Эрдэнэцогт
Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар					
	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, 1,2,3 дугаар улирлын төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгааны тайлбар, жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт болон 109.700.0 мянган төгрөгийн орлого, худалдан авалтыг мэдээлээгүй	109.7	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Б.Батсайхан, Ж.Баатар
Нийслэл дэх Цагдаагийн удирдах газар					
	Шилэн дансны цахим хуудсанд цалингаас бусад 5 саяас дээш гүйлгээг илүү, дутуу оруулж, өссөн дүнгээр мэдээлээгүй, 48.815.3 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримт байхгүй	48.8	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Р.Отгонжаргал, Л.Батсүрэн
Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газар					
	цахим и-баримтын дүнгээс бараа материал, ажил үйлчилгээний төлбөрийг зөрүүтэй шилжүүлсэн, шилэн дансны цахим хуудсанд 305.290.8 мянган төгрөгийн мэдээлэл дутуу байршуулсан	83.6	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	М.Батсайхан, Т.Туул
Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газар					
	Цахим и-баримтын дүнгээс зөрүүтэй гүйлгээ хийсэн, шилэн дансны цахим хуудсанд зарлагын 3, худалдан авалтын 2 гүйлгээ мэдээлээгүй, тооллогын бүртгэлийн бэлэн бүтээгдэхүүний дүн санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй	31.7	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	П.Очбадрах, Ч.Нарантунгалаг
Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газар					
	Шилэн дансны цахим хуудсанд зарлагын 1 гүйлгээ мэдээлээгүй, 2 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, татварын цахим төлбөрийн баримтын системд 43.989.2 мянган төгрөг дутуу, 802.6 мянган төгрөг илүү бүртгэсэн	44.8	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Б.Даваазул, Г.Алтанцэцэг
	Тээврийн хэрэгслийн ашиглах шатахуунаас өөр төрлийн шатахуун зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу	2.8	Албан шаардлага	Дарга Ахлах нягтлан бодогч	Б.Даваазул, Г.Алтанцэцэг
Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн газар					
	Цахим бүртгэлийн системд и-баримт дутуу бүртгэсэн, анхан шатны бүрдэл дутуу ажил гүйлгээ хийсэн	103.3	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Г.Цэргийнхүү, Б.Тэргүүнбат
Хан уул дүүрэг дэх Цагдаагийн газар					
	Бараа материалд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгө бүртгэлтэй, шатахууныг их хэмжээгээр нөөцөлсөн, татварын цахим системд 47.188.0 мянган төгрөг бүртгээгүй, шилэн дансны цахим хуудсанд орлогын 12, зарлагын 43 гүйлгээг буруу /илүү/ мэдээлсэн	80.4	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Т.Дамбийням, Б.Пүрэвжав
Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газар					
	Худалдан авалтын болон ажил үйлчилгээ гүйцэтгүүлэхэд гарсан зардал татварын цахим системд дутуу бүртгүүлсэн	32.0	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Б.Шинэбаатар, Б.Сонинхүү
Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс					
	Цахим Е баримтын дүнгээс зөрүүтэй төлбөр шилжүүлж, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй	4.6	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Л.Ариунбат, Ц.Сэлэнгэ

	Цахим Е баримтын дүнгээс зөрүүтэй төлбөр шилжүүлсэн, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээ хоцроож байршуулсан	2.9	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Л.Ариунбат, Ц.Сэлэнгэ
Багахангай дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс					
Налайх дүүрэг дэх Цагдаагийн хэлтэс					
	Цахим Е баримтын дүнгээс зарим худалдан авалт болон ажил үйлчилгээний төлбөрийн баримт зөрүүтэй төлбөр шилжүүлсэн	9.2	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Л.Ариунбат, Ц.Сэлэнгэ
Дорноговь аймгийн Замын үүд сум дундын Цагдаагийн хэлтэс					
	Алба хаагчдын ажлыг улирлаар дүгнээгүй сар бүр дүгнэсэн, акталсан эд хөрөнгийг данснаас хассан боловч устгал хийгээгүй	-	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Ц.Эхбаатар, Д.Отгончимэг
Сэлэнгэ аймгийн Мандал сум дундын Цагдаагийн хэлтэс					
	Бараа материалын хөдлөл өөрчлөлтийг тухай бүр бус оны эцэст бөөн дүнгээр бүртгэсэн, цалингийн тооцооны өглөгийг буруу бүртгэсэн, алба хаагчдад арилжааны банкаар олгож байгаа мөнгөний жагсаалтад банкны гүйлгээний тэмдгээр баталгаажуулалт хийлгээгүй, шилэн дансны 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	3,118.5	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Б.Ганхуяг, З.Гийхнаран
Сэлэнгэ аймгийн Сайхан сум дундын Цагдаагийн хэлтэс					
	Шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн	-	Зөвлөмж	Дарга Ахлах нягтлан бодогч	Б.Энхчулуун, Ч.Эрдэнэ-Очир
	ДҮН	2,448.3			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 415/А0160060

Улаанбаатар хот

СМН-2021/05/СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлант хугацаанд оруулбал зохих 7897 мэдээллээс 336 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь байршуулж, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны дарга, Цагдаагийн хурандаа П.Батбаатар, Ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүүгийн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа Н.Алтансүх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

АХЛАХ АУДИТОР

Д.ЦЭРЭНДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 416/АД160060

Улаанбаатар хот

СМ 2021/05/СМ-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны урсгал зардлын төсвөөс дараах үндсэн хөрөнгийг бэлтгэсэн байна. Үүнд: 445.0 сая төгрөгийн 300 ширхэг суурин компьютер, 63.6 сая төгрөгийн 40 ширхэг зөөврийн компьютер, 42.0 сая төгрөгийн архивын 60 ширхэг шүүгээ, нийт 550.6 сая төгрөгийн хөрөнгийг урсгал зардлын багаж, техник хэрэгслийн зардлын төсвөөс бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний үүргийг хангуулж, гүйцэтгэлийг актаар баталгаажуулж, хөрөнгийг бүртгэн, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны дарга, Цагдаагийн хурандаа П.Батбаатар, Ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүүгийн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа Н.Алтансүх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Д.ЦЭРЭНДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 417/АД160060

Улаанбаатар хот

СДГ-2021/05/СТА-ТТӨ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагдаагийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цагдаагийн ерөнхий газрын харьяа төсвийн шууд захирагчдын /Нийслэл, орон нутгаас бусад/ 2020 оны батлагдсан төсөвт орон тоо 3571, гүйцэтгэлээр 3783 буюу 212 орон тоогоор хэтэрсэн байна. Засгийн газрын 2016 оны 4 дүгээр тогтоолоор Цагдаагийн ерөнхий газрын төв байрны албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг 298-р баталснаас 88 орон тоогоор илүү байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан цалингийн сан, батлагдсан орон тооны хязгаарт багтаан ажиллаж, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны дарга, Цагдаагийн хурандаа П.Батбаатар, Ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүүгийн хэлтсийн дарга, Цагдаагийн хурандаа Н.Алтансүх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Д.ЦЭРЭНДОРЖ